



ГОВЬСҮМБЭР АЙМАГ
ШИВЭЭГОВЬ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2025 оны 02 сарын 21 өдөр

Дугаар 1/35

Шивээговь сум

Хөрөнгө зарцуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1, Захиргааны ерөнхий хуулийн 43 дугаар зүйлийн 43.1, 46 дугаар зүйлийн 46.1, Төсвийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.2.3, сумын Засаг даргын 2025 оны 01 дүгээр сарын 03-ны өдрийн А/02 дугаар захирамж, Шивээговь сумын Иргэдийн төлөөлөгчдийн хурлын 2024 оны 12 дугаар сарын 30-ны өдрийн 08 дугаар “Сумын 2025 оны төсөв батлах тухай” тогтоолыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ НЬ:

1.Сумын Засаг даргын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт туссан арга хэмжээнүүдийн 2025 онд хэрэгжүүлэх төлөвлөгөөний дагуу Ерөнхий боловсролын сургуулийн 6-12 дугаар ангийн суралцагчийг “Сүү” хөтөлбөрөөр хангахад 19,002,000 (арван есөн сая хоёр мянга) төгрөгийг зарцуулсугай.

2.“Сүү” хөтөлбөрт зарцуулагдах төсвийг хавсралтаар баталсугай.

3.Тус хөтөлбөрт зарцуулагдах 19,002,000 (арван есөн сая хоёр мянга) төгрөгийг хөтөлбөрт суурилсан арга хэмжээний зардлаас зарцуулахыг Ахлах нягтлан бодогч (Л.Туяа)-д зөвшөөрсүгэй.

4.Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газрын дарга (Д.Отгонжаргал)-д үүрэг болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Ч.СУГАРМАА

Сумын Засаг даргын 2025 оны 02 -р сарын 21 -ны өдрийн 41/35 дугаар захирамжийн хавсралт



Ерөнхий боловсролын сургуулийн 6-12 дугаар
ангийн суралцагчийн сүү хөтөлбөрийн төсөв

№	Он сар	Сурагчдын тоо	Нэгжийн үнэ	1 сард олгох сүүний зардал /4удаа/
1	2025 оны 2-р сар	421	1,500	2,526,000
2	2025 оны 3-р сар	421	1,500	2,526,000
3	2025 оны 4-р сар	421	1,500	2,526,000
4	2025 оны 5-р сар	421	1,500	2,526,000
5	2025 оны 9-р сар	421	1,500	2,526,000
6	2025 оны 10-р сар	421	1,500	2,526,000
7	2025 оны 11-р сар	421	1,500	2,526,000
8	2025 оны 12-р сар	440	1,500	1,320,000
НИЙТ				19,002,000

-----oOo-----